



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/668

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ховд аймгийн Жаргалант сумын Бичигт багт инженерийн хийцтэй ухаалаг худаг гаргасан ажлыг хүлээн авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Бямбажав - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналт хариуцсан мэргэжилтэн

Н.Ганбат - "Шим-Ус" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга

З.Уянга - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн мэргэжилтэн

С.Бат-Эрдэнэ - Бичигт багийн Засаг дарга

У.Батзаяа - "Эвлэл" ХХК-ийн захирал

О.Бадамцэцэг - Шим-Ус" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын инженер

Нарийн бичгийн

дарга: Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Инженерийн хийцтэй ухаалаг худаг гаргасан ажлыг хүлээн авахтай холбогдон гарах зардлыг тухайн төслийн техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

/Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Тухайн ажлыг төсвийн дагуу шалгаж, норм нормативыг баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг улсын комиссын дарга /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН